



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/270

Хэрлэн сум

**Тэмцээнийг зохион байгуулах
зардалд хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.7, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ахлах ангийн сурагчдын эрүүл мэндийг дэмжин бие бялдрыг чийрэгжүүлэх,хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой 5x5 Сагсан Бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулах зардалд 1,860,000 (нэг сая найман зуун жаран мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 15-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шүүгчдийн хөлс	3 шүүгч	200,000	600,000
2	Цом /том/	2ш	110,000	220,000
3	Цом /жижиг/	6ш	30,000	180,000
4	Өргөмжлөл	6ш	70,000	420,000
5	Савхин өргөмжлөл	1ш	55,000	55,000
6	Мандат	40 ш	4,000	160,000
7	Аяга	17 ш	10,000	170,000
8	Энгэрийн тэмдэг	10 ш	5,500	55,000
	Нийт			1,860,000